

**Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам
Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль**

Банзарын Мөнгөн

**Төрөлтийн өд эpidурал өвдөлт намдаах арга
хэрэглэсэн өр дйн**

Е- 7202280 Анестезиологи

Анагаах ухааны магистрын зэрэг горилж бичсэн бтээлийн
хураангуй

Улаанбаатар хот
2005 он

Судалгааны ажлыг ЭНЭШТ-ийн (Захирал Эрхэмбаатар. АУ-ы доктор) ЭБЭК-ийн (Захирал С.Хишгээ Кл.Проф) Эхийн нэгдгээр тасаг (Тасгийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч Б.Цэдэнхорлоо), Эрчимт эмчилгээ мэдээгйжүүлгийн тасаг (Тасгийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч С.Амармандах), Нярайн тасагт (Тасгийн эрхлэгч С.Лхамсүрэн АУ-ы доктор) хийж гйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч :

АУ-ы доктор Ліндэгийн Ганболд

Эрдэм шинжилгээний ажлын зєвлєх :

МУ-н Ардын эмч,тєрийн шагналт, Профессор Гонийн Лхагважав

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч :

АУ-ы доктор, Профессор Бадамхандын Шижирбаатар

Магистрын хамгаалалт ЭМШУИС-ийн Эрдмийн зєвлєлийн єрєєнд 2005 оны ... сарын ...-ны єдрийн ... цагт болно.

**Тараахыг зєвшєєрєв. Анагаахын сургуулийн эрдмийн
зєвлєлийн нарийн бичгийн дарга
АУ-ны доктор Г.Наран**

Нэг. Судалгааны ажлын үндэслэл

Орчин үед манай жирэмсэн эхчүүд төрөлтийн үеийн өвдөлтөөс айж түгших, үүний улмаас өвдөлтгүй төрөх хүсэлт гаргах нь нэмэгдсэн, жирэмсэн эхийн хүсэлтийг харгалзан үзэх, төрөлттэй холбоотой бусад эрсдэлийг бууруулах зорилгоор төрөлтийн үеийн өвдөлт намдаах эмчилгээний аргыг судлах шаардлагатай болов. Өвдөлт намдаах эмчилгээний аргууд нь зөвхөн төрөлтийн үеийн өвдөлтийг намдаах төдийгүй эх ба урагт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нь чухал болно.

Өнөөдөр дэлхийн олон орнуудад жирэмсэн эхчүүдийн төрөлтийн үед өвдөлт намдаах төрөл бүрийн аргуудыг сонгон хэрэглэж байна.

Жил бүр төрөгч эмэгтэйчүүдийн 60% буюу 2,4 сая хүн төрөлтийн өвдөлт намдаах арга болгож эпидурал, эпидурал-нугасны хосолсон өвдөлт намдаах аргыг сонгож байна [Holger K.Eltzschig, Ellice S.Lieberman 2002]. 1997-1998 онд Их Британид төрсөн эхчүүдийн 24% нь орчны өвдөлт намдаалт (нугасны, эпидурал) хийлгэсэн байна [Jones P.I. 2001]. Төрөх үеийн өвдөлт намдаах орчин үеийн аргуудаас Эпидурал Өвдөлт Намдаах Арга (ЭДӨНА) дийлэнх хувийг эзэлж байна. Америкт нийт төрсөн эхчүүдийн 50%-аас илүүтэй нь ЭДӨН хийлгэж төрсөн байна [Robert D.Vincent M.D and David H.Chestnut 1998. November].

“ Өвдөлт намдаахыг хүссэн эмэгтэйн хүсэлт нь төрөлтийн үед өвдөлт намдаах арга хэрэглэх заалт мөн. ” гэж АНУ-ын эх барих эмэгтэйчүүдийн нийгэмлэг ба мэдээгүйжүүлэгчдийн нийгэмлэг хамтран мэдэгдсэн байна.

Эх барихын мэдээгүйжүүлэлтийн орчин үеийн хөгжилд төрөлтийн өвдөлт намдаалтын үед хэрэглэх аргууд, эмийн бодисууд нь эх ба урагт хамгийн бага сөрөг нөлөө үзүүлдэг байх шаардлагатай [Расстригин Н.Н. 1982]. Амьсгалын зам, судсаар болон булчинд тарих аргаар хэрэглэж буй эмийн бодисууд нь өвдөлт намдаах сайн үйлчилгээтэй боловч өндөр тунгаар хэрэглэх үед төрөгч эхийг унтуулах, төрөх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чадахгүй болгох сөрөг нөлөөтэй [Шанина Ю.Н.1982; Hermont 1981].

Төрөлтийн үед ЭДӨНА хэрэглэхэд эх ба урагт хэрхэн нөлөөлж байгаа нь өнөөдрийг хүртэл анхаарал татсан асуудал бөгөөд энэ талаар судалгааны ажлууд хийгдсээр байна.

Иймээс бид төрөлтийн үед ЭДӨНА-ыг сонгон авч хэрэглэснээр төрөгч эхийн амин чухал эрхтэн системийн үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгаа болон умайн базлалтын хүч, үргэлжлэх хугацаа, базлалт хоорондын зай, ургийн байдалд хэрхэн

нөлөөлж байгаа зэргийг судалж, энэ аргыг өөрийн эмнэлэг, тасгийн ололт амжилтанд тулгуурлан цаашид боловсруулахаар ажиллаж байна.

Хоёр. Судалгааны ажлын зорилго

Төрөлтийн үеийн өвдөлтийг эпидурал аргаар намдааснаар эхийн төрөх үеийн өвдөлтийн хүч, амин чухал эрхтэн системийн үзүүлэлтүүд (артерийн агшилтын ба сулралтын даралт, зүрхний агшилтын тоо, амьсгалын тоо, артерийн цусны хүчилтөрөгчийн ханамж), умайн базлалтын хүч, үргэлжлэх хугацаа, базлалт хоорондын зай зэрэгт хэрхэн нөлөөлөхийг судлана.

Гурав. Судалгааны ажлын зорилтууд

1. Төрөлтийн үеийн өвдөлтийн хүчийг тоон шалгуурт үнэлэмж (ТШҮ)-ийн аргаар хэмжиж өвдөлтийн хүчээс хамааруулан эпидурал аргаар өвдөлт намдаах, ЭДӨНА-ыг хэрэглэхэд төрөлтийн үеийн өвдөлтийн хүчийг хэрхэн бууруулж байгааг судалж тогтоох
2. Төрөлтийн үеийн өвдөлтийн хүч нь умайн хүзүүний нээлтээс хамааралтай эсэхийг тодорхойлох
3. Эпидурал өвдөлт намдаалт хийхээс өмнөх ба хийсний дараах үеийн амин чухал эрхтэн системийн үзүүлэлтүүд, умайн базлалтын хүч, үргэлжлэх хугацаа, базлалт хоорондын зай, ургийн байдлыг харьцуулах
4. Эпидурал өвдөлт намдаах эмчилгээ хийлгэж төрсөн эхчүүдийн нярайн Апгарын үнэлгээг өвдөлт намдаалт хийгээгүй төрсөн эхчүүдийнхтэй харьцуулан судлах зорилтыг тавив.

Дөрөв. Судалгааны ажлын шинэлэг тал

1. Манай нөхцөлд анх удаа жирэмсэн эхчүүдийн эпидурал зайд гуурс тавьж төрөлтийн туршид өвдөлт намдаах тасралтгүй аргыг хэрэглэж үр дүнг судалсан.
2. Төрөлтийн үед эпидурал өвдөлт намдаах аргыг харьцангуй эрүүл эхчүүдэд хэрэглэж, өвдөлт намдаалтын хийснээр амин чухал эрхтэн системийн үзүүлэлтүүд болох артерийн даралт, зүрхний агшилтын тоо, амьсгалын тоо, артерийн цусны хүчилтөрөгчийн ханамж хэрхэн өөрчлөгдөж байгааг судалсан ажил юм.
3. Мөн ЭДӨНА арга нь өвдөлт намдаалт хийлгэсэн эхчүүдийн умайн базлалтын хүч, үргэлжлэх хугацаа, базлалт хоорондын зай, ургийн байдалд

хэрхэн нөлөөлж байгааг өвдөлт намдаалт хийгээгүй эхчүүдийнхтэй харьцуулан судалсан зэрэг нь шинэлэг зүйл болов.